

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ ТӨСВИЙН  
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2026.06.24

Улаанбаатар хот

**Нэг.** Хяналт-шинжилгээний зорилго

Биеийн тамир, спортын улсын хорооны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2026 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

**Хоёр.** Хяналт-шинжилгээ хийх үндэслэл, дүгнэх арга зүй

Биеийн тамир, спортын улсын хорооны 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний 2026 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны "Журам батлах тухай" 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ыг удирдлага болгов.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 4 зорилт бүхий 48 арга хэмжээнээс 45 арга хэмжээ тус бүрийн биелэлтийг зорилтот түвшин, үр дүнтэй нь харьцуулан үнэлсэн. Хяналт-шинжилгээний ажлын явцад зарим тайлан мэдээллийн хэрэгжилтийн байдалд нэмэлт тодруулга авах, асуудал хариуцсан нэгжээс тайлбар авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулах, бататгах ажлыг гүйцэтгэв.

**Гурав.** Гүйцэтгэлийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээний үр дүн.

"Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 2.5-д заасны дагуу Биеийн тамир, спортын улсын хорооны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн баталсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 4 зорилт 48 арга хэмжээнээс 2026 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд тайлагнавал зохих 45 арга хэмжээнд хяналт-шинжилгээ хийхэд 34 арга хэмжээ "бүрэн хангалттай" буюу 85 түүнээс дээш хувь, 8 арга хэмжээ "хангалттай" буюу 70-85 хүртэл хувь, 3 арга хэмжээ "хангалтгүй" буюу 70 хүртэл хувьтай тус тус үнэлэгдэж гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж **92,1** хувьтай буюу "бүрэн хангалттай" гэж дүгнэгдлээ.

Хүснэгт 1

Нийт арга хэмжээ	Арга хэмжээний зорилт, хэрэгжилтийн үнэлгээ			Хувь
45	Бүрэн хангалттай	Хангалттай	Хангалтгүй	Дундаж хувь
	100 хүртэл хувьтай арга хэмжээ	85 хүртэл хувьтай арга хэмжээ	70 хүртэл хувьтай арга хэмжээ	<b>92,1</b>
	34 арга хэмжээ	8 арга хэмжээ	3 арга хэмжээ	

Шинэчлэгдэн батлагдсан журмын хүрээнд хяналт-шинжилгээ хийхэд нийт арга хэмжээний 75,5 хувь нь бүрэн хангалттай буюу 100-85 хувь, 17,8 хувь нь хангалттай буюу 85-70 хувь, 6,7 хувь нь хангалтгүй буюу 70 хүртэл хувьтай байна.

График 1



Хүснэгт 2  
2026 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн үнэлгээний задаргаа

№	Дэс дугаар	Арга хэмжээ	Гүйцэтгэл ийн хувь
<b>НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУССАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</b>			
<b>Зорилт-1.1</b> Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг нэмэгдүүлнэ.			
1	1.1.1	Хүн амын идэвхтэй хөдөлгөөн, спортын талаарх мэдлэг, хандлага, дадлыг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулах;	95%
	1.1.2	Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг хянах сорилын төвийн хэвийн үйл ажиллагааг хангах;	100%
	1.1.3	Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа спортын барилга байгууламжийн мэдээлэл шинэчлэх;	100%
<b>Зорилт-1.2</b> Биеийн тамир, спортыг хөгжүүлэх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.			
2	1.2.1	Биеийн тамир спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал хүргүүлэх;	80%
	1.2.2	Үндэсний спортын тухай анхдагч хуулийн төсөлд санал хүргүүлэх;	50%
	1.2.3	Биеийн тамир спортын тухай хуулийг дагаж гарах эрх зүйн баримт бичгийн төсөлд санал хүргүүлэх;	100%
<b>Зорилт-1.3</b> Спортын наадам, үндэсний шигшээ багийн нэгдсэн бэлтгэл цугларалтыг зохион байгуулна.			
3	1.3.1	Спортын сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагаанд спортын дасгалжуулалтын шинжлэх ухааны дэвшилтэд арга зүйг нэвтрүүлэх буюу өсвөр үеийн шигшээ багийн нэгдсэн бэлтгэл цугларалтыг зохион байгуулах; /улсын хэмжээнд/	80%
	1.3.2	Монголын оюутны спортын VII наадам зохион байгуулах;	100%
	1.3.3	Монголын үндэсний спортын өвлийн VIII наадам зохион байгуулах;	100%
	1.3.4	Монголын үндэсний спортын зуны VIII наадам зохион байгуулах;	90%
	1.3.5	Үндэсний уламжлалт спортын төрлийн орон нутгийн брэнд арга хэмжээг эрчимжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;	100%

<b>Зорилт 1.4</b> Тив дэлхийн болон Монгол Улсад зохион байгуулагдах олон улсын тэмцээний бэлтгэл зохион байгуулалтыг ханган, дэмжлэг үзүүлнэ.			
4	1.4.1	Монгол Улсад 2026 онд зохион байгуулагдах олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Засгийн газрын тогтоолын дагуу дэмжлэг үзүүлэх, спортын холбоодтой хамтран ажиллах, хяналт тавих;	100%
	1.4.2	Олон улсын хүүхдийн XII наадамд өсвөрийн баг тамирчдыг оролцуулах, дэмжлэг үзүүлэх;	Хугацаа болоогүй
	1.4.3	Үндэсний шигшээ багуудыг "Милан Кортина-2026" өвлийн олимп, паралимпийн наадамд эрх авч оролцоход дэмжлэг үзүүлэх;	100%
	1.4.4	"Лос Анжелес 2028" олимп, паралимпийн наадам, Азийн наадам, Азийн паралимпийн наадамд оролцох эрх авах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;	100%
	1.4.5	Азийн наадамд Үндэсний шигшээ багийн бус тамирчдыг оролцуулах;	Хугацаа болоогүй
	1.4.6	Бүгд Найрамдах Киргиз улсын Бишкек хотноо зохиогдох "Дэлхийн нүүдэлчдийн VI наадам"-д Монгол улсын баг, тамирчдыг оролцуулах;	90%
<b>Зорилт 1.5</b> Допингийн эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлнэ.			
5	1.5.1	Дэлхийн допингийн эсрэг байгууллагын татвар, ЮНЕСКО-ийн сайн дурын хандивын зардал гаргах шийдвэр гаргуулах;	80%
	1.5.2	Дэлхийн допингийн эсрэг дүрэм болон допингийн эсрэг үндэсний дүрмийн хэрэгжилтийг хангах	100%
<b>ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ</b>			
<b>Зорилт.2.1</b> Биеийн тамир, спортын мэргэжлийн холбоод, олон нийтийн байгууллага, хувийн хэвшлийн багууллагатай хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлнэ.			
6	2.1.1	Спортын өндөр амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагчдад нэг удаагийн мөнгөн шагнал олгох;	100%
	2.1.2	Олимп, паралимпийн наадам, ДАШТэмцээнээс олимпын жин, зайд медаль хүртсэн тамирчдад сар бүр мөнгөн урамшуулал олгох;	100%
	2.1.3	Биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжтэй хамтын ажиллагааны тогтолцоог хөгжүүлэх;	85%
	2.1.4	Хүүхэд хамгаалал, ёс зүй, аюулгүй спортын орчны стандарт нэвтрүүлэх;	100%
	2.1.5	Спортын дасгалжуулагч, Биеийн тамирын арга зүйчийн мэргэшил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах;	100%
	2.1.6	Биеийн тамир, спортын асуудлаар гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;	100%
<b>ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ</b>			
<b>Зорилт.3.1</b> Төрийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны болон хүний нөөцийн нэгдсэн удирдлагаар хангана.			
	3.1.1	Биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулах, батлуулах;	60%
	3.1.2	Орон нутгийн Биеийн тамир, спортын байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийг боловсруулан батлах, хүргүүлэх;	Хугацаа болоогүй
	3.1.3	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх хүрээн дэх арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах;	100%
	3.1.4	Салбарын албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;	100%
	3.1.5	Төсвийн тухай хуулийн хүрээнд төсөв, санхүүг төлөвлөх, хуваарь батлах, хэрэгжилтийг хангах;	100%
	3.1.6	Мэдээллийн ил тод байдал, Мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжилтийг хангах sport.gov.mn вэб сайтад нийтлэх, түгээх;	100%
	3.1.7	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан	100%

	сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах;	
3.1.8	Байгууллагын 2026 оны Хяналт-шинжилгээ үнэлгээний төлөвлөгөөг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөө, хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх;	80%
3.1.9	Салбарын харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнгийн үзүүлэлт, үнэлгээнд дүн шинжилгээ хийх, биелэлтэд нь хяналт тавих, сургалт зохион байгуулах;	100%
3.1.10	Байгууллагын болон харьяа газар, хэлтсүүдийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйгээр хангах;	100%
3.1.11	Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим сангийн бүрдүүлэлт;	100%
3.1.12	Мэдээллийн ил тод байдал шилэн индексийн системийн Shilen.gov.mn-н ашиглалтыг сайжруулах;	100%
3.1.13	Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг боловсруулах, ашиглах, хадгалах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах;	80%
3.1.14	Хүүхэд хамгааллын тухай хуулийн /52 дугаар зүйлийн 52.7 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь хэсэг/ хэрэгжилтийг хангах;	80%
3.1.15	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн хэрэгжилтийг ханган ажиллах;	100%
3.1.16	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах;	100%
3.1.17	Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангах;	100%
3.1.18	Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах;	100%
3.1.19	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах;	85%
3.1.20	Эрсдэлийн удирдлагын арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах;	60%
<b>ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ</b>		
<b>Зорилт 4.1</b> Төрийн үйлчилгээг ил тод, хурдан шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэнэ.		
4.1.1	Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн хэрэгжилтийг хангах, Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хос бичгээр хөтлөх;	70%
4.1.2	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах;	100%
4.1.3	2025 оны статистик мэдээний эмхэтгэл гаргах;	80%
<b>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дүн</b>		<b>92,1%</b>

### Дөрөв. Дүгнэлт

Биеийн тамир, спортын улсын хорооны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн баталсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2026 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн дундаж “Бүрэн хангалттай” буюу 85 түүнээс дээш хувьтай үнэлэгдсэн байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4 зорилт бүхий 48 арга хэмжээнээс 3 арга хэмжээ нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийн хугацаа болоогүй тул 2026 оны эхний хагас жилийн үнэлгээнээс хасаж тооцов. Тайлагнавал зохих 45 арга хэмжээнээс 29 арга хэмжээ 100% хэрэгжсэн байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 2.5.3. “Төлөвлөгөөний хэрэгжилт 70 хүртэл хувь бол “хангалтгүй” гэж үнэлэгдсэн гурван арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна. Үүнд:

Арга хэмжээ 1.2.2 “Үндэсний спортын тухай анхдагч хуулийн төсөлд санал хүргүүлэх”, 3.1.1 “Биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулах, батлуулах”, 3.1.20 “Эрсдэлийн удирдлагын арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах”.

Биеийн тамир, спортын улсын хорооны 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлтийн тухайд шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг ончтой тодорхойлж, шалгуур үзүүлэлт бүр нь хэмжих боломжтой хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээ уялдсан байна. Мөн зорилтот түвшинг бодит нөхцөл байдал, хүрэх үр дүнтэй нийцүүлэн тодорхойлсон нь хэрэгжилтийн явцыг бодитой үнэлэх боломжийг бүрдүүлжээ. Үүний давуу тал нь хэрэгжилтийн үр дүнг тогтмол хянах, үнэлэх, шаардлагатай тохиолдолд сайжруулах арга хэмжээг төлөвлөхөд дэмжлэг болохуйц байна. Төлөвлөлт өмнөх оноос сайжирсан нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээний тайлангаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан нь харагдаж байна.

Мөн 2026 оны эхний хагас жилийн тухайд гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг системээр тайлагнадаг болсон нь тайлагналтын үйл ажиллагааг илүү шуурхай, ил тод, үр ашигтай зохион байгуулах давуу талыг бүрдүүлж байна. Системд тайланг нэгтгэн оруулснаар арга хэмжээний давхардал буурахын зэрэгцээ биелэлтийг нотлох баримтад үндэслэн дүгнэх, хэрэгжилтийг бодит цаг хугацаанд хянах, баталгаажуулах боломж сайжирсан. Мөн тайлангийн мэдээллийг хадгалах, хайх, харьцуулах, дүн шинжилгээ хийх ажиллагаа хялбар болж, хяналт-шинжилгээ, үнэлгээ болон удирдлагын шийдвэр гаргалтыг бодит мэдээлэлд үндэслэн хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Гэвч системд төлөвлөгөөний хэрэгжилт оруулах явцад 1.3.1, 1.3.4, 1.4.6 зэрэг арга хэмжээний биелэлт тайлагнах хугацаа болоогүй хэдий ч гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хугацааг буруу төлөвлөснөөс шалтгаалан системд тухайн арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах шаардлага үүссэн байна. Тодруулбал дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа нь эхний хагас жилд хүрэх зорилгот түвшинтэйгээ уялдаагүй байгаа нь үнэлгээ буурах үндэслэл болсон байна.

**Тав. Зөвлөмж:** Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ.

1. Хэрэгжих хугацаа тодорхойгүй, төлөвлөлт буруу хийгдсэн арга хэмжээ тус бүрийг онцгойлон анхаарч, арга хэмжээг эрчимжүүлэх, хэрэгжилтийг “бүрэн хангалттай” үр дүнд хүргэн ажиллах;
2. “Бүрэн хангалттай”, “хангалттай” үнэлэгдсэн арга хэмжээний үр дүнг цаашид бууруулахгүйгээр 2026 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 100 хувьд хүргэхэд анхаарч ажиллах зэрэг зөвлөмжийг хүргүүлж байна.

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:  
ХШУДАХ-ИЙН ДАРГА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:  
ХШУДАХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН



Н.БАТСҮХ

Д.УРАНБИЛИГ

ATA13270 911891 9024090207